2107	Томилолт, зочны зардал	448,100.00
210702	Дотоод албан томилолт	448,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,487,588.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,487,588.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,228,830.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,870,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,400,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,470,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	358,830.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	358,830.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,416,560.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,416,560.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,416,560.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,804,636.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	152,804,636.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,490,590.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	133,705,802.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,608,244.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	169,791.44
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	169,791.44

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сумын Засаг дарга Х.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-нөөс 2021 оны 03 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, үе шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар хийж, ахлах аудитор П.Содном гүйцэтгэв.

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/29 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган аймгийн Бугат сумын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Бугат-шинэ хөгжил” үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

Үйл ажиллагааны хөтөлбөр дараах 11 чиглэлээр зорилго дэвшүүлэн ажиллажээ.

“Эрүүл чийрэг – Бугат” Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл бие, саруул ухаан, сайхан сэтгэл” уриан дор аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Биеийн тамирын чиглэлээр: Биеийн тамираар хичээллэх орчин бүрдүүлэн идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгон хэвшүүлэхэд шаардагдах биеийн тамирын хэрэгсэл материалаар ханган, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны хэрэгцээг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, ажлын байрыг бий болгоход чиглэсэн боловсрол сургалтын үйл ажиллагааг дэмжиж албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулан “ажлын байр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Нийгмийн хамгаалал, халамж: Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх халамж хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жөндөрийн тэгш байдлыг нийгмийн бүх салбарт хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

Эрдэм боловсролтой – Бугат: Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг боловсрол, соёлын түвшинд төлөвшүүлнэ.

СӨБ-ийн чиглэлээр: Боловсролын байгууллагын төрөл, чанар хүртээмжийг сайжруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Соёл, урлагийн чиглэлээр: Эрүүл бие, саруул ухаан, сайхан сэтгэл” уриан дор аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Байгаль орчны чиглэлээр: Төв суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож ногоон хөгжлийн загвар сум болгон хөгжүүлнэ.

Мал аж ахуйн чиглэлээр: нийт малын сүргийн бүтцийг зохистой болгон, үүлдвэрлэг байдлыг сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх.

Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр: Эрүүл бие, саруул ухаан, сайхан сэтгэл” уриан дор аливаа төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Нийтийн хэв журмын чиглэлээр: Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэнд ээлтэй эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ.

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын чиглэлээр: Булган аймгийн Бугат сумын нийт суурьшлын бүсийг хаягийн болон дэд бүтцийг хөгжүүлэх иргэдийн амьдрах таатай нөхцөлөөр хангах.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/ 424 дүгээр захирамжаар баталсан байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн нийт зардал 2455901.4 мянган төгрөгийн 2 хувь буюу 49118.0 мянган төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 39294.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 116519.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 228795.6 мянган төгрөг болж, 112276.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт	Хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Төрийн сангийн харилцах	191217.5	178900.2	-12317.3	
Арилжааны банк	1128.5		-1128.5	
Нэмэлт санхүүжилт		169.8		
Дүн	192345.9	179070.0	-13275.9	

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 178900.2 мянган төгрөгийн 88926.6 орон нутгийн ерөнхий орлогын данс дахь давсан орлого болон урьд оны үлдэгдлээс зарцуулагдаагүй үлдэгдэл байна. ОНХС дансанд дахь 5707.1 мянган төгрөг нь хэрэгжүүлээгүй 1 төсөл арга хэмжээний үлдэгдэл, сум хөгжүүлэх сан, ЖДҮДС-ийн 61921.0, Эрүүл мэндийн төвийн 11119.5 мянган төгрөг тус тус байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй 254.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан /ИТХ/
- Ерөнхий журналаас бараа ажил үйлчилгээний бусад зардлыг мөнгөн гүйлгээний тайлантай тулган баталгаажуулахад зардлын эдийн засгийн ангилал зөрчин шатахуун бичиг хэрэг, шагнал урамшуулал, шуудан холбоо, хичээл үйлдвэрлэлийн зардал зэрэгт зарцуулсан байна. /ЗДТГ/
- Цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмж олгосон /ЕБС /

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 250458.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 301524.2 мянган төгрөг болж, 51065.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл

/мян.төг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү (+-)
1	Ажиллчидтай холбогдсон авлага	6415760.87	4,502,096.05	(1,913,664.82)
2	Татааас санхүүжилтийн авлага		62,832,800.00	62,832,800.00
3	Зээлийн хүүгийн авлага	2,997,650.70	1,218,941.70	(1,778,709.00)
4	Байгууллагаас авах авлага	21,944,871.49	13,027,887.03	(8,916,984.46)
5	Хувь хүмүүсээс авах авлага	219,100,147.53	219,942,434.53	842,287.00

	Дүн	250,458,430.59	301,524,159.31	51,065,728.72
--	-----	----------------	----------------	---------------

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажилчдаас авах авлагын 4502.1 мянган төгрөг нь цалингийн урьдчилгааны авлагаар 4 хүний 2889.8, НДШ-ийн илүү шилжүүлсэн 776.1, урьд оны авлага болох 1217.2 мянган төгрөг нь 2018 онд татварын тооцоогоор иргэдээс авах ХХОАТ-ыг эзэн холбогдогчгүй авлага, цалингийн урьдчилгааны авлагыг шүүхийн байгууллагад хандаж 2022 оны 5 сард төлүүлэхээр эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

Татаас санхүүжилтийн авлага 62832.8 мянган төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах ЭМТ-ийн авлага байна.

Байгууллагаас авах авлагад Эрүүл мэндийн төвийн иргэнээс авах түлээний үнэ 8751.3 мянган төгрөг нь шүүхийн шийдвэртэй боловч төлөгдөөгүй байна. Мөн 2002 онд үүссэн төсөл хөтөлбөрөөс зээл авсан иргэдээс авах авлагыг ОНТЕО дансанд авлагаар тусгаж энэ нь эзэн холбогдогчгүй байна.

Хувь хүмүүсээс авах авлагын 141254.7 мянган төгрөг нь сум хөгжүүлэх, 56551.3 ЖДҮДС, 20000.0 мянган төгрөг нь ОНХС-гийн малжуулах төслийн малын авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны санхүүгийн тайлангийн 633.3 авлага, 283.9 мянган төгрөгийн өглөг дансны үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /ЕБС /

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 288,980.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 380,716.8 мянган төгрөг болж, мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төг/ Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	20,567.96	61,291.54	40,723.5
Бичиг хэрэг	3,961.39	3,509.81	-451.5
Аж ахуйн материал	226,097.68	266,945.40	40847.7
Сэлбэг хэрэгсэл	3,064.63	3,521.81	457.2
Түлш, шатах тослох материал	2,895.55	5,651.55	2756
Хүнсний материал	4,908.81	3,565.30	-1343.5
Бусад хангамж	2,964.90	11,711.40	8746.5
Нөөцийн бараа	-	-	0
Мал амьтад	24,520.00	24,520.00	0
Дүн	288,980.91	380,716.81	91735.9

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 255844.1, хандив тусламжаар 169797.6, бусад эх үүсвэрээс 155.0 мянган төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 334060.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, бусад болон акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

Нийт бараа материалын үлдэгдлийг байгууллагаар харуулбал

Хүснэгт № 4 Бараа материалын үлдэгдэл байгууллагаар

/мян.төгрөг/

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	2,226.2	3,712.7	1486.5
2	ЗДТГ	74,311.8	72,740.3	-1571.5
3	Хүн эмнэлэг	58,441.3	109,748.2	51306.9
4	Цэцэрлэг	31,142.8	45484.9	14342.1
5	Сургууль	107284.7	133172.1	25887.4
6	Соёлын төв	15574	15858.5	284.5
	Дүн	288,980.8	380,716.7	91,735.9

Нийт бараа материалын 34.9 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 28.8 хувийг Эрүүл мэндийн төв, 19.1 хувийг ЗДТГ, 11.9 хувийг хүүхдийн цэцэрлэг, 4.1 хувийг соёлын төв, 0.9 хувийг ИТХ-ын хөрөнгө тус тус эзэлж байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,356,383.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,948,527.3 мянган төгрөг болж 592,143.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн 74.5 хувийг барилга байгууламж, 6.6 хувийг машин тоног төхөөрөмж, 5.4 хувийг авто тээврийн хэрэгсэл, 2.2 хувийг тавилга эд хогшил, 3.6 хувийг бусад биет бус хөрөнгө 0.5 хувийг ном эзэлж байна.

Хүснэгт № 5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	Барилга байгууламж	4015987.2	4429102.8	413115.6
2	Авто тээврийн хэрэгсэл	302367.4	319867.4	17500
3	Машин тоног төхөөрөмж	335209.9	397303.4	62093.5
4	Тавилга, аж ахуйн эд хогшил	120155.8	134099.7	13943.9
5	Түүх дурсгал	16280	16280	0
6	Бусад үндсэн хөрөнгө	313417	396814.2	83397.2
7	Дуусаагүй барилга байгууламж			0
8	Ном	30264.9	31008.3	743.4
9	Программ хангамж	7595.5	8945.5	1350
10	Бусад биет бус хөрөнгө	215106	215106	0
	Дүн	5356383.7	5948527.3	592143.6

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 34564.5, хандив тусламжаар 350508.6 мянган төгрөгийн хөрөнгө нь сургуулийн дотуур байр ашиглалтад орсон, шилжүүлэн авсан 456019.8 мянган төгрөг нь сургуулийн хуучин дотуур байрыг цэцэрлэгт шилжүүлсэн холбоотой авсан нэмэгдэж, бусад 209132.8 нийт 1050225.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 452587.5, акталсан 5494.8 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Хүснэгт № 6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
1	ИТХ	7,979.30	12494.3	4,515.00

2	ЗДТГ	1,630,524.90	1884150.9	253,626.00
3	Хүн эмнэлэг	751,018.50	803113.6	52,095.10
4	Цэцэрлэг	56,993.90	466955.4	409,961.50
5	Сургууль	2,797,676.60	2698622.5	(99,054.10)
6	Соёлын төв	83,190.60	83190.6	-
7	Сум хөгжүүлэх сан	29,000.00		(29,000.00)
	Дүн	5,356,383.80	5,948,527.30	592,143.50

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн 45.5 хувийг Ерөнхий боловсролын сургууль, 31.7 хувийг сумын ЗДТГ, 13.5 хувийг Эрүүл мэндийн төв, 7.8 хувийг хүүхдийн цэцэрлэг, 1.5 хувь нь соёлын төвийн үндсэн хөрөнгө байна.

Аудитын илрүүлэлт:

- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртгийг шинэчлэн үнэ тогтоох, акталж устгах арга хэмжээ аваагүй байна. /Сургууль, ЗДТГ/

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15977.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6278.8 мянган төгрөг болж, 9699.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон өглөг	50,000.00	734,709.00	684,709.00
Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,831,858.96	1,467,848.94	(9,364,010.02)
Байгууллагаас авах авлага	5,072,435.00	4,001,235.00	(1,071,200.00)
Хүмүүст өгөх өлөг	23,548.00	75,048.00	51,500.00
Дүн	15,977,841.96	6,278,840.94	(9,699,001.02)

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өглөгийн 827.7 мянган төгрөг нь ЗДТГ, 24.2 ИТХ-ын, 1218.9 сум хөгжүүлэх сангийн, 283.9 ерөнхий боловсролын сургуулийн, 1508.1 хүн эмнэлгийн, 2416.0 орон нутгийн хөгжлийн сангийн эзэн холбогдогчгүй өглөг байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5471070.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5777043.3 мянган төгрөг болж, 305972.8 мянган төгрөгөөр өссөн байна

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, Бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1484959.4	1484959.4	0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			0
Хуримтлагдсан үр дүн	2415008.1	3242037.1	827029
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1310574.9	1050046.8	-260528.1
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	260528.1		-260528.1
Дүн	5,471,070.50	5,777,043.30	305,972.80

Эх сурвалж: Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5777043.3 мянган төгрөг болж 305972.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1,050,046.8 мянган төгрөг болж 260,528.1 мянган төгрөгөөр буурсан нь сумын ерөнхий боловсролын сургуулийн барилга шилжүүлсэнтэй холбоотой дахин үнэлгээтэй хөрөнгө акталж түүний дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 161,291.4 мянган төгрөгийн татварын орлого, 1,243,358.5 мянган төгрөгийн татварын бус орлого, 2,300,037.8 мянган төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 3,704,687.7 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого тайлагнагдсан байна. Тусламж санхүүжилтийн орлогын 957,896.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,110,799.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 210,857.2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 20,484.5 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Сумын ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 03-ний өдрийн 04 дугаар тогтоолоор сумын 2021 оны төсвийн жилд зарцуулах төсвийг 2,027,273.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,928,541.4 мянган төгрөг буюу 93.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.5.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын ИТХ-ын 2021 оны 08 дүгээр сарын 03-ний өдрийн 04 дугаар тогтоолоор сумын 2021 оны төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 116610.7, татварын бус орлогыг 20900.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр тайлант онд 183469.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 133.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мян.төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	137,510.70	183,468.90	45,958.20	133.42
ТАТВАРЫН ОРЛОГО	116,610.70	161,291.40	44,680.70	138.32
Хувь хүний орлогын албан татвар	33,100.00	30,502.40	-2,597.60	92.15
Үйл ажиллагааны орлого	9,100.00	12,294.70	3,194.70	135.11
Хадгаламжийн хүүгийн орлого	11,500.00	15,511.50	4,011.50	134.88
Шууд бус орлого	12,500.00	2,696.20	-9,803.80	21.57
Хөрөнгийн албан татвар	3,300.00	55,982.90	52,682.90	1,696.45
Бууны албан татвар	3,300.00	3,510.00	210.00	106.36
Малын тоо толгойн албан татвар		44,258.90	44,258.90	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		8,214.00	8,214.00	
Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,000.00	13,779.40	779.40	106.00
Улсын тэмдэгтийн хураамж	4,200.00	4,686.90	486.90	111.59
Түгээмэл тархац	5,000.00	5,005.60	5.60	100.11

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,800.00	4,086.90	286.90	107.55
Газрын төлбөр	3363.4	7211.4	3,848.00	214.41
Газрын төлбөр	3363.4	7,211.40	3,848.00	214.41
Байгалийн нөөц ашигласны төлбөр	63,847.30	53,815.30	-10,032.00	84.29
Ойн нөөц ашигласны төлбөр	61,347.30	49,865.30	-11,482.00	81.28
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,000.00	472.00	-528.00	47.20
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,500.00	3,478.00	1,978.00	231.87
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,900.00	22,177.50	1,277.50	106.11
Нийтлэг татварын бус орлого	20,900.00	22,177.50	1,277.50	106.11
хүү, торгуулийн орлого	14,000.00	17,978.00	3,978.00	128.41
Нэр заагдаагүй орлого	6,900.00	4,199.50	-2,700.50	60.86

Сумын төсөвт 13 нэр төрлийн 137510.7 мянган төгрөгийн орлого оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр нийт дүнгээрээ 183,468.90 мянган төгрөгөөр буюу 113.4 хувиар давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 3194.7, хадгаламжийн хүүгийн орлого 4011.5, улсын тэмдэгтийн хураамж 486.9, газрын төлбөр 3848.0, ус рашаан ашигласны төлбөр 1978.0, торгуулийн орлого 3978.0 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол малын тоо толгойн албан татвар 44258.9, үл хөдлөх хөрөнгийн албан татварын 8214.0 төгрөгийн орлого нь төлөвлөгөөгүй орлого байна.

Тайлан онд шууд бус орлого 9803.8 мянган төгрөгөөр тасарсан нь цар тахлын улмаас аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллагаа зогссонтой холбоотой, ойн нөөц ашигласны төлбөр 11482.0 мянган төгрөгөөр тасарсан нь Ойн нөөц ашигласны төлбөрийг 1-р бүсчлэлээр тооцохоор төлөвлөж гэтэл тусгаарлалтыг 3-р бүсчлэл гэж ангилан эрх олгосонтой холбоотой зөрүү үүссэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2,061,410.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,930,969.0 сая төгрөгийг урсгал зардалд, 130,714.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2061410.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээс 957,896.6, орон нутгийн төсвөөс 770614.1, орон нутгийн хөгжлийн сангаас 37973.0, эрүүл мэндийн даатгалын сангаас 21024.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 110160.4, урьд оны санхүүжилтээс 163741.4 мянган төгрөгийг орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 934,738.5, орон нутгийн төсвөөс 782,925.9, орон нутгийн хөгжлийн сангаас 37,973.0, эрүүл мэндийн даатгалын сангаас 17,032.7, үйл ажиллагааны орлогоос 115,213.9 нийт 1,887,884.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 115213.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 5053.6 мянган төгрөгөөр давж биелсэн нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 12,490.6, дээд шатны төсвийн захирагчаас 133,705.8, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6,608.2 нийт 152804.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 17042,9, НДШ 419,2, хангамж бараа материалын зардалд 2070.6, норматив зардалд 66521.1, томилолтын зардалд 448.1, бараа үйлчилгээний зардал 14487.6, урсгал шилжүүлэгт 46228.8 нийт 152634.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 169.8 мянган төгрөгийг үлдэгдэл нь Эрүүл мэндийн төвийн дансанд үлдсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 141 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 554.0 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	554.0	3	554.0			100
Нийт							

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдаж, 2 байгууллага буюу байгаль хамгаалах сан, ЖДҮДС нэгтгэсэн тайланд нэгтгэн тайлагнасан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 5 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 112082.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлсэн захирагчид 112082.4 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 203317.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 1839.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 142245.6 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 59232.6 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлж, алдаа зөрчил өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд орлогын биелэлт их хэмжээгээр давсан орлогын төлөвлөлтийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Авлагын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагууд тайлант оны эцэст ЗДТГ 4883.2, Соёлын төв 817.6, Цэцэрлэг 934.3, ЕБС 719.9, Эрүүл мэндийн төв 8751.3, төрийн сангийн 2082.0 мянган төгрөгийн авлага үлэгдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагын тайлант оны болон өмнөх онуудын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж бүрэн барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

4.2 Өглөгтэй холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагууд тайлант оны эцэст ОНХС-гийн татварын байгууллагатай холбоотой 2416.0, сум хөгжүүлэх сангийн 1218.9, ЗДТГ-ын 827.7, ЕБС 283.9, Хүн эмнэлэг 1508.1 ИТХ-ын 24.2 мянган төгрөгийн тайлант онд болон өмнөх онуудын өглөг байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж: Тайлант оны болон өмнөх онуудын өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж өглөгийг бүрэн барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 45958.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь үл хөдлөх хөрөнгийн орлогын албан татвар 8214.0, Малын хөлийн тоо толгойн албан татвар 44258.9 мянган төгрөгийн төлөвлөөгүй орлого орсон нь нөлөөлсөн байна. Ойн нөөц ашигласны төлбөр 11482.0, ан амьтаны нөөц ашигласны татвар 528.0, шууд бус орлого 9803.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогын биелэлтэнд дүн шинжилгээ хийж, давсан орлогыг төлөвлөх боломжтой эсэх талаар судалгааг хийж, орлогын төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

4.4 Шилэн данстай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 2020 онд Шилэн дансны цахим хуудсанд 141 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, хуульд заасан мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж хэвших.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Асуудлын бүртгэлээр танилцуулж зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.